



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 1/206

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26.3 дахь заалт, Засгийн газрын 1997 оны 52, 53 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” 2012 оны 142 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Эрүүл мэнд, спортын яамнаас шагнал олгоход мөрдөх журам”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэнд, спортын яамны шагнаалд нэр дэвшиүүлэх ажилтны танилцуулгын маягт”-ыг хоёрдугаар, “Эрүүл мэнд, спортын яамны шагнаалд нэр дэвшиүүлэх ажилтны жагсаалтын маягт”-ыг гуравдугаар, “Байгууллагын ажилтны шагналын судалгааны маягт”-ыг дөрөвдүгээр, “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, “Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн загварыг тавдугаар, Яамны “Хүндэт дэвтэр”-ийн тодорхойлолт, Хүндэт дэвтэрт бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээний тодорхойлолт, загварыг зургаадугаар, Яамны “Жуух бичиг”-ийн загварыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 363 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
- Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т даалгасугай.

САЙД

С.ЛАМБАА



080776

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 05 сарын 31. өдрийн
4/206 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНААС ШАГНАЛ ОЛГОХОД МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын эрүүл мэнд, спортын салбарыг хөгжүүлэх, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үйлст үр бүтээлтэй ажиллаж онцгой амжилт гаргасан эрүүл мэндийн ажилтан, биеийн тамир спортыг хөгжүүлэхэд болон спортын төрөлд өндөр амжилт гаргасан иргэнийг Засгийн газрын болон Эрүүл мэнд, спортын яамны шагнал (цаашид "шагнал" гэх)-аар шагнахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Шагналын төрөл

2.1. Шагнал нь Засгийн газрын 1997 оны 52, 53 дугаар тогтоолд заасны дагуу дор дурдсан төрөлтэй байна.

2.1.1. Засгийн газрын шагнал:

- “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;
- “Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;

2.1.2. Эрүүл мэнд, спортын яамны шагнал:

- Яамны “Хүндэт дэвтэр”-т бичиж дурсгалын гэрчилгээ олгох;
- Яамны “Жуух бичиг”-ээр шагнах.

Гурав. Шагнал олгох болзол

3.1. Шагналыг шат дараалан, давхардуулахгүйгээр олгох бөгөөд ажлын амжилт, бүтээл нь өмнөх түвшингээс ахисан нөхцөлд дараагийн шагнаалд нэр дэвшүүлнэ. Онцгой гавъяа байгуулсан тохиолдолд Эрүүл мэнд, спортын сайдын шийдвэрээр шагналыг болзол харгалзахгүйгээр олгож болно.

3.2. Эрүүл мэндийн болон биеийн тамир спортын байгууллага нь энэхүү журмын 3.5, 3.6, 3.8-д заасан болзол хангасан ажилтанг дараах хяналтын тооноос хэтрүүлэхгүйгээр шагнаалд нэг удаад нэр дэвшүүлнэ: Хяналтын тоог ажиллагсдын 0,5 хувиас хэтрүүлэхгүй байвал зохино.

3.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар, яамны харьяа байгууллагууд энэхүү журмын 3.5, 3.6, 3.8-д заасан болзол хангасан ажилтанг нийт ажиллагсдын 0,5 хувиас хэтрүүлэхгүйгээр шагнаалд нэг удаад нэр дэвшүүлж Эрүүл мэнд, спортын яаманд уламжилна:

3.4. “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан”, “Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийг бусад салбарын “Тэргүүний ажилтан” хүндэт тэмдэгтэй давхардуулан олгохгүй байх зарчмыг баримтална.

3.5. “**Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан**” хүндэт тэмдгээр эрүүл мэндийн ажилтанг шагнахдаа дор дурьдсан болзлыг харгалzan үзнэ:

- 3.5.1. төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа, дутагдал гаргаагүй;
- 3.5.2. ажил мэргэжлийн ур чадвар, үйл ажиллагаа, мэргэжлийн түвшингээр бусад ажилтанг манлайлан ажилласан;
- 3.5.3. Яамны “Жуух бичиг”-ээр шагнагдаад 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан.

3.6. “**Биеийн тамир спортын тэргүүний ажилтан**” хүндэт тэмдгээр ажилтан, иргэнийг шагнахдаа дор дурьдсан болзлыг харгалzan үзнэ:

- 3.6.1. төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа, дутагдал гаргаагүй;
- 3.6.2. ажил мэргэжлийн ур чадвар, үйл ажиллагаа, мэргэжлийн түвшингээр бусад ажилтанг манлайлан ажилласан, биеийн тамир спортыг хөгжүүлэхэд бодит нэмэр оруулсан;
- 3.6.3. Яамны “Жуух бичиг”-ээр шагнагдаад 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан;
- 3.6.4. Олон улс, тив, дэлхийн болон улсын аварга шалгаруулах тэмцээнд тогтвортой амжилт гаргасан, тив, дэлхий, улсын рекордыг шинэчлэн тогтоосон тамирчдад журмын 3.6.1-3.6.4-т заасан болзлыг хангаж байвал хугацаа харгалзахгүйгээр олгож болно.
- 3.6.5. Спортын мастераас дээш цолын болзол хангасан, улсын шигшээ багийн тамирчнаар сонгогдсон тамирчдад шууд олгож болно.

3.7. Яамны “Хүндэт дэвтэр”-т эрүүл мэндийн болон биеийн тамир спортын салбарт тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж, “Монгол Улсын баатар”, “Монгол Улсын Хөдөлмөрийн баатар”, “Монгол Улсын Ардын эмч”, “Монгол Улсын Хүний Гавьяат эмч”, “Монгол Улсын Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан”, “Монгол Улсын гавьяат дасгалжуулагч”, “Монгол Улсын гавьяат тамирчин” хүндэт цол, “Монгол Улсын Төрийн шагнал” хуртсэн хүмүүсийн нэрийг бичиж, дурсгалын гэрчилгээ олгоно.

3.8. Яамны “**Жуух бичиг**”-ээр ажилтанг шагнахдаа дор дурьдсан болзлыг харгалzan үзнэ:

- 3.8.1. төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа, дутагдал гаргаагүй;
- 3.8.2. ажил мэргэжлийн ур чадвар, үйл ажиллагаа, мэргэжлийн түвшингээр үусад ажилтанг манлайлан ажилласан;
- 3.8.3. хариуцсан ажлын үзүүлэлт сүүлийн 3-5 жилд улс, хот, аймгийн дундаж түвшингээс дээш байсан;
- 3.8.4. эрүүл мэндийн болон биеийн тамир спортын салбарт 10-аас (сум, багт 5-аас) доошгүй жил ажилласан.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, уламжлах

4.1. Шагналыг жил бүрийн Сар шинийн баяр, Дэлхийн эмч нарын өдөр, Олон улсын эх баригч, сувилагчдын өдөр, Тамирчдын өдөр, Эрүүл мэндийн салбарын ажилтны өдөр, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтолцоо сэргээсний баярыг тохиолдуулан олгоно. Мөн эрүүл мэндийн болон биеийн тамир спортын байгууллагын 50-аас дээшхи 10 жил тутмын тэмдэглэлт тэгш ойг тохиолдуулан шагнаж болно.

4.2. Төрийн захиргааны төв байгууллагын шийдвэргүй эмнэлгийн байгууллагын ой, алба, тасаг нэгж, Засаг, захиргааны нэгжийн ой, салбарын бус байгууллагын ойгоор шагнал урамшуулалт олгохгүй.

4.3. Шагналд нэр дэвшүүлэх санаачлагыг үндсэн байгууллага (улсын болон хувийн хэвшилийн эрүүл мэнд, биеийн тамир спортын байгууллага)-ын хамт олон гаргаж, хурлаар хэлэлцэнэ. Хамт олны хурлын ирцэд нэр дэвшигчийн харьяалагдаж буй нэгжийн хамт олны 80-аас доошгүй хувь байх шаардлагатай бөгөөд хуралд оролцогсдын 90-ээс доошгүй хувь нь шагналд нэр дэвшүүлэхээр зөвшөөрвөл хурлын тэмдэглэлийг баталгаажуулан, байгууллагын захиргаанд уламжилна.

4.4. Байгууллагын захиргаа шагналд нэр дэвшигчийн талаар Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны саналыг авсны үндсэн дээр Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дэмжсэн тохиолдолд тодорхойлолт гаргах бөгөөд байгууллагын дарга тодорхойлолтонд гарын үсэг зурж, тамга дарна.

4.5. Байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан албан тушаалтан энэхүү журмын 4.6, 4.7-д заасан баримт бичгүүдийг бүрдүүлж, шагналд нэр дэвшүүлэх ажилтны жагсаалтыг энэхүү тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргаж харьяалах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт журмын 4.1-д заасан тэмдэглэлт өдөр болохоос 45-аас доошгүй хоногийн өмнө албан бичгээр уламжилна. Үиеийн тамир спортын байгууллага, сургуулийн хувьд аймаг, нийслэлийн спортын хороогоор уламжлан, Биеийн тамир спортын газарт хүргүүлнэ.

4.6. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар, Эрүүл мэнд, спортын яамны харьяа байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн шагнаалд нэр дэвшигчдийн бичиг баримтын бүрдэлт, үнэн зөв байдал, хяналтын тоонд багтсан эсэхийг нягтлан үзэж, нэгтгэсний үндсэн дээр Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бөгөөд дэмжигдсэн ажилтнуудын жагсаалтыг энэхүү тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж журмын 4.7-д заасан баримт бичгийн хамт цахим буюу цаасан хэлбэрээр журмын 4.1-д заасан тэмдэглэлт өдөр болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө Эрүүл мэнд, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.

4.7. Шагнаалд нэр дэвшүүлж тодорхойлохдоо дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

- 4.7.1. Байгууллагын хамт олны хурлын албан тэмдэглэл;
- 4.7.2. Ажил байдлын тодорхойлолт /ажлын үр дүн, шинэ бүтээл, санаачилсан тэргүүн туршлага зэргийг тооцоо судалгаатай, тоон үзүүлэлттэй/;
- 4.7.3. Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны санал /эмнэлгийн мэргэжилтэнд хамаарна/;
- 4.7.4. Урьд шагнагдсан бол түүний хуулбар;
- 4.7.5. Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар;
- 4.7.6. Шагнуулах тухай байгууллагын даргын гарын үсэгтэй албан бичиг;
- 4.7.7. Шагнуулах тухай харьяалах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газрын болон шууд харьяа байгууллагын даргын гарын үсэгтэй албан бичиг;
- 4.7.8. Харьяалах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газрын Даргын дэргэдэх зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр.
- 4.7.9. Тэтгэвэрт гарсан өндөр настны материалд хөдөлмөрийн дэвтрийн хуулбарыг заавал хавсаргана;
- 4.7.10. Энэхүү тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан танилцуулгын маягт /цахим хэлбэрээр/;

4.8. Шагналтай холбоотой баримт бичгийг энэхүү журмын 4.7-д заасны дагуу бүрдүүлээгүй, хугацаа хожимдуулж ирүүлсэн тохиолдолд Эрүүл мэнд, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газар тухайн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар, яамны харьяа байгууллагад баримт бичгийг буцаана.

4.9. Шагналтай холбоотой баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд шагнал олгохгүй ба тухайн ажилтанг дараагийн 3 жилд аливаа нэг шагнаалд нэр дэвшүүлэхгүй байвал зохино.

Тав. Шагнах асуудлыг шийдвэрлэх

5.1. Эрүүл мэнд, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн холбогдох байгууллагаас шагнаалд нэр дэвшүүлж ирүүлсэн баримт бичгийг хүлээн авч хянаж, энэхүү журмын 3.5, 3.6, 3.8-д заасан болзлыг хангасан ажилтнуудын талаар асуудал боловсруулан Төрийн нарийн

бичгийн даргын дэргэдэх “Удирдлагын зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт гаргана. “Удирдлагын зөвлөл”-ийн хурлаас гарсан дүгнэлтийг Эрүүл мэнд, спортын сайдад танилцуулах ба шагнах асуудлыг Эрүүл мэнд, спортын сайдын тушаал гаргаж шийдвэрлэнэ.

5.2. Яамны “Хүндэт дэвтэр”-т бичих шийдвэрийн төслийг Эрүүл мэнд, спортын яамны Төрийн захирагааны удирдлагын газрын шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулах ба Төрийн нарийн бичгийн даргын тушаал гаргаж шийдвэрлэнэ.

5.3. “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан”, “Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, Яамны “Хүндэт дэвтэр”-т бичигдсэн тухай гэрчилгээ, Яамны “Жуух бичиг”-т хувийн дугаарыг бичих ба шагнагдсан ажилтнуудын хүндэт тэмдэг, үнэмлэх, “Жуух бичиг”-ийг харьялах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар, Яамны харьяа байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

Зургаа. Шагнал гардуулах, мэдээлэх

6.1. “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийг үнэмлэхийн хамт, яамны “Жуух бичиг”-ийг Эрүүл мэнд, спортын сайд болон Эрүүл мэнд, спортын яамны удирдах ажилтнууд, орон нутагт аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, эмнэлгийн удирдлага ёслол төгөлдөр гардуулна.

6.2. “Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийг үнэмлэхийн хамт, яамны “Жуух бичиг”-ийг Эрүүл мэнд, спортын сайд болон Эрүүл мэнд, спортын яамны удирдах ажилтнууд, орон нутагт аймаг, нийслэлийн Биеийн тамир спортын хороо, нийгэмлэгийн удирдлага ёслол төгөлдөр гардуулна.

6.3. Яамны “Хүндэт дэвтэр”-т бичигдсэн тухай гэрчилгээг тухайн шагнагдсан ажилтанд Эрүүл мэнд, спортын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын эзгүйд Эрүүл мэнд, спортын яам яамны Төрийн нарийн бичгийн дарга яамны ёслолын танхимд ёслол хүндэтгэлтэйгээр гардуулна.

6.4. Засгийн газраас тогтоосон дагалдах мөнгөн шагнал (“Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан”, “Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг 100000 төгрөг, “Жуух бичиг” 30000 төгрөг)-ыг тодорхойлсон байгууллага, яамны “Хүндэт дэвтэр”-т бичигдсэн тухай гэрчилгээ, амьд цэцгийн баглааны зардлыг Эрүүл мэнд, спортын яам хариуцна. Шагналаар шагнасан, гардуулсан тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно.

Долоо. Хүндэт тэмдэг, үнэмлэхийг нөхөн болон сольж олгох

7.1. Хүндэт тэмдэг, үнэмлэх, гэрчилгээ, "Жуух бичиг"-ийг үргэдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд нөхөн болон сольж олгож болох ба дараахь материалыг бүрдүүлэн Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт уламжилна:

- 7.1.1. үргэдүүлсэн, гэмтээсэн нөхцөл шалтгааныг тодорхой бичсэн хүсэлт бүхий өргөдөл;
- 7.1.2. иргэний үнэмлэхний хуулбар;
- 7.1.3. үнэмлэх, "Жуух бичиг"-ийг хүчингүй болгож зарлуулсан баримт;
- 7.1.4. шагнасан шийдвэрийн хуулбар;
- 7.1.5. гэмтсэн зүйлс.

7.2. Эрүүл мэнд, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн өргөдлийг хянаж үзээд хүндэт тэмдэг, үнэмлэх, гэрчилгээ, "Жуух бичиг"-ийг нөхөн болон сольж олгох үндэслэлтэй гэж үзвэл хэвлүүлсэн зардлыг З нугалсан хэмжээний төлбөрийг холбогдох байгууллага, иргэнээс Эрүүл мэнд, спортын яамны дансанд шилжүүлсний дараа олгоно.

Найм. Шагналын мэдээллийн сан

8.1. Эрүүл мэнд, спортын яам нь шагнагдсан ажилтнуудын цахим мэдээллийн сантай байна. Санг шагналын төрөл, орон нутаг, байгууллага, оноор төрөлжүүлэн бүрдүүлнэ.

8.2. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөнийг Эрүүл мэнд, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцна.

8.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар, яамны харьяа байгууллагууд нь ажилтнуудын шагналын бүртгэл, мэдээллийн сантай байх ба байгууллагын хүний нөөцийн менежер шинээр шагнагдсан ажилтнуудын шагналын судалгааг энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу шинэчилж, жил бүрийн 6, 12 дугаар сарын 15-ны дотор Эрүүл мэнд, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газарт цахим хэлбэрээр ирүүлнэ.

Ес. Хариуцлага

9.1 Шагналтай холбоотой бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлж ирүүлсэн байгууллагын дарга, холбогдох албан тушаалтын асуудлыг Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх "Удирдлагын зөвлөл"-ийн хурлаар хэлэлцүүлж, зохих хариуцлагыг хүлээлгэ

Эрүүл мэнд спортын сайдын
2016 оны 05 сарын 31... өдрийн
4/206 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

Эрүүл мэнд, спортын яамны шагналд нэр дэвшүүлэх
ажилтны танилцуулгын маягт

1. Ургийн овог _____
2. Эцэг/эхийн нэр _____
3. Өөрийн нэр _____
4. Регистрийн дугаар _____
5. Нас, хүйс _____
6. Яс үндэс _____
7. Боловсрол _____
8. Үндсэн захиргаа _____
9. Урьд эрхэлж байсан ажил (оны дарааллаар):

3x4 зураг

10. Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал:

11. Нийт ажилласан жил —

12. Үүнээс тухайн хамт олны дотор _____

13. Урьд нь авч байсан гавьяа шагнал (оны дарааллаар, яамны "Жуух бичиг"-ээр шагнагдсан бол хуулбарыг заавал хавсаргана).

14. Горилж буй шагналын нэр _____

15. Шагнуулах үндэслэл /тодорхой бичнэ/

16. Тухайн хүний ажлын үндсэн үзүүлэлтийг хүснэгтээр гаргаж хавсаргана. (сүүлийн 5 жилээр харьцуулан, дэлгэрэнгүй бичнэ)

17. Хамт олны саналын хувь _____

Анкетыг баталгаажуулсан:

Хүний нөөцийн менежер _____ /Нэр/

Гарын үсэг

Огноо

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 05 сарын 31.. өдрийн
1206 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

**ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНЫ ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ
АЖИЛТНЫ ЖАГСААЛТЫН МАЯГТ***

а/ Салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр

№	Овог нэр	Нас, хүйс	Регистерийн дугаар	Ажилласан жил	"Жуух бичиг"-ээр шагнагдсан тушаалын огноо, дугаар	Эрхэлж байгаа албан тушаал,	Бүрдүүлсэн материалын жагсаалт
1							
2							
3							

б/ Яамны "Жуух бичиг"-ээр шагнагдах хүмүүс

№	Овог нэр	Нас, хүйс	Регистерийн дугаар	Ажилласан жил	Одоогийн албан тушаал	Бүрдүүлсэн материалын жагсаалт
1						
2						
3						

*Маягтыг бөглөхдөө үсгийн хэлбэр "Ариал", үсгийн хэмжээ "12"-ыг ашиглана.

*Шагналд нэр дэвшүүлэх ажилтны жагсаалтыг шагналын төрөл /Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан, БТСТА, "жуух бичиг"/-өөс хамаарч маягтын дагуу тус, тусад нь гаргана.

*Энэ хүснэгтийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар, яамны харьяа байгууллагууд гаргаж цахим хэлбэрээр, софтоор ирүүлнэ.

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 12 сарын 31. өдрийн
12 дугаар тушаалын 4 дүгээр
хавсралт

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР, БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАР
/ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА/-Т
АЖИЛЛАГСДААС 201 ОНД
ТӨРИЙН ДЭЭД ЦОЛ, ОДОН МЕДАЛИАР
ШАГНАГДСАН ХҮМҮҮСИЙН СУДАЛГАА


№	Овог нэр	Нас, хүйс	Ажил ласан жил	Албан тушаал	Шагнагдсан төрийн дээд цол, одон медалийн нэр, зарлигийн огноо, дугаар
1					
2					
3					
4					
5					

*Энэхүү судалгааг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний байдлаар Яамны харьяа байгууллагууд болон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар нэгтгэн гаргаж албан тоотоор, цахим хэлбэрээр ирүүлнэ.

* Судалгаанд зөвхөн Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар /Хөдөлмөрийн баатар, Ардын болон гавьяат зүтгэлтэн, Сүхбаатарын одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан түгийн одон, Алтан гадас одон, Хөдөлмөрийн хүндэт медалиар/ шагнагдсан хүмүүсийг хамруулна.

**Шагнагдсан зарлигийн огноо, дугаарыг заавал бичнэ.

* Маягтыг бөглөхдөө үсгийн хэлбэр “Ариал”, үсгийн хэмжээ “12”-ыг ашиглана.



Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 05 сарын 31. өдрийн

1/206 дугаар тушаалын 5 дугаар
хороролт

“ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН”, “БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” ХҮНДЭТ ТЭМДГИЙН ЗАГВАР

“Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг нь ромбо хэлбэртэй, эргэн тойрон алхан хээ бүхий цагаан хүрээтэй, уг хүрээнийхээ оройд соёмботой, ромбын дунд хэсэгт нь Монгол Улсын төрийн далбааны дэвсгэр дээр хундага ороосон мөгийг алтлаг өнгөөр дүрсэлсэн, тэмдгийн доод хэсгийг ороосон алтлаг шар өнгийн туузан дэвсгэр дээр “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” гэж монгол үсгээр бичсэн байна.

“Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг нь ромбо хэлбэртэй, хоёр талаараа эртний олимпийн ялалтын билэгдэл бүхий навчин хүрээтэй, ромбын дээд хэсэгт хөх цэнхэр дэвсгэр бүхий тойротг соёмбо, түүний доод хэсэгт улаан өнгөөр асаж буй галт бамбарыг дүрсэлсэн, тэмдгийн доод хэсгийг ороосон алтлаг шар өнгийн туузан дэвсгэр дээр “Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” гэж монгол үсгээр бичсэн байна.

Тэмдгийн урт нь 40.0 мм, өргөн нь 26.0 мм, зузаан нь 2.5 мм байна.

“Тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагшагдагсадад хувийн дугаар бүхий үнэмлэх олгоно.

ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР

Үнэмлэх нь 95x140 мм-ийн хэмжээтэй голоор нь нугалж, зүүн талд нь тухайн тэмдэгний зураг, дугаарыг байрлуулж баруун талд нь:

..... овогтой

..... Танаа

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах /Биеийн тамир спортыг хөгжүүлэх/ үйлсэд оруулсан хувь нэмрийг тань үнэлж Эрүүл мэнд, спортын сайдын оны дугаар сарын ... өдрийн тоот тушаалаар Засгийн газрын шагнал “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” /“Биеийн тамир спортын тэргүүний ажилтан”/ хүндэт тэмдгээр шагнаж үнэмлэх олгов.

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД...../нэр/
... он сар өдөр

Улаанбаатар

гэсэн бичээстэй, гадуураа тэмдгийн зураг бүхий улаан өнгийн хавтастай байна.

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 05 сарын 31, өдрийн
Ч.Доржсүрэн дугаар тушаалын 6 дугаар
хавсралт

ЯАМНЫ ХҮНДЭТ ДЭВТРИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хүндэт дэвтэр нь хатуу хавтастай, хавтасны өнгө нь улаан, хавтасны гадна дээд хэсгийн голд Төрийн сүлдтэй, сүлдний доод талд “Хүндэт дэвтэр” гэж монгол үсгээр алтан шаргал өнгөөр бичсэн байна.

Хүндэт дэвтрийн доторхи хуудаснуудыг өлзий утсан хээтэй нимгэн хатуу цаасаар хийж, дээд хэсгийн голд нь “Хүндэт дэвтэр”-т бичигдсэн хүний 9x12 хэмжээний фото зургийг байрлуулсан байна.

Зургийн доод хэсэгт тухайн хүний байгуулсан гавьяя, эрүүл мэндийн салбарт оруулсан хувь нэмэр, ажлын амжилтыг бэхээр цэвэр үзэмжтэй бичиж, “Хүндэт дэвтэр”-ийн дурсгалын гэрчилгээ олгосныг тэмдэглэнэ.

“Хүндэт дэвтэр”-ийг цахим хэлбэрээр бүрдүүлэн ашиглаж болно.

ДУРСГАЛЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ, ЗАГВАР

Хүндэт дэвтэрт бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээг А4 хэмжээний хатуу, алтлаг өнгийн цаасан дээр гоёмсог өлзий утсан хүрээ бүхий цагаан дэвсгэр дээр доорх загвараар хэвлэнэ:

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ
Төрийн соёмбо

ХҮНДЭТ ДЭВТРИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар

..... овогтой

..... Танаа


Хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах /Биеийн тамир спортыг хөгжүүлэх/ үйлсэд Таны оруулсан хувь нэмэр, гавьяя зүтгэлийг үнэлж салбарын түүхэнд тэмдэглэн Эрүүл мэнд, спортын яамны “Хүндэт дэвтэр”-т бичиж гэрчилгээ олгов.

Эрүүл мэнд, спортын сайд.....

... он сар өдөр

Улаанбаатар

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 05 сарын 31 өдрийн
11/206 дугаар тушаалын 7 дугаар
хавсралт



"ЖУУХ БИЧИГ"-ИЙН ЗАГВАР

"Жуух бичиг" нь 220x315 мм-ийн хэмжээтэй улаан хүрэн өнгийн хавтастай байх бөгөөд хавтасны нүүрэн талын дээд хэсэгт "Эрүүл мэнд, спортын яам", гол хэсэгт Төрийн сүлд, түүний доод хэсэгт "Жуух бичиг" гэсэн үгийг монгол үсгээр хэвлэнэ.

"Жуух бичиг"-ийн доторхи хуудас нь 210x297 хэмжээтэй, голоор нь нугалж, зүүн талд соёмбо, жуух бичгийн хувийн дугаарыг байрлуулж баруун талд нь:

..... овогтой
..... Танаа

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах /Биеийн тамир, спортыг хөгжүүлэх/ үйлсэд идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, төр засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг тань үнэлж, Эрүүл мэнд, спортын сайдын ... оны ... дугаар сарын ны өдрийн ... тоот тушаалаар Эрүүл мэнд, спортын яамны "Жуух бичиг"-ээр шагнав.

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД...../нэр/

... он, сар, өдөр

Улаанбаатар

гэж бичнэ.